

**ГОЛОМТ БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/		
Тайлагнах хугацаа	2024.01.01 – 2024.06.30	
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: Голомт банк ХК РД: 2075377 Хаяг: Голомт банкны Төв байр, Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22 Улаанбаатар 15160, Монгол улс Утас: 1800-1646 (24/7) 7011-1646 (Дотуур утас) Факс: 11-313155 И-мэйл: mail@golomtbank.com Веб сайт: golomtbank.com	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	808,657,306 ширхэг	
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Э.Тэлмэн /Хөрөнгө оруулалтын менежер/ Тайлан хянасан: З.Солонго /ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга/	
1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын тайлан /Хавсралт №1/	
	Орлогын тайлан /Хавсралт №1/	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан /Хавсралт №1/	
	Мөнгөн гүйлгээний тайлан /Хавсралт №1/	
2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	/Хавсралт №2/

3 Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт

3.1 Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

Голомт банкны 2024 оны 1-р хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн голлох үр дүн

- Голомт банк олон улсын зах зээл дээрээс гурван жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондыг амжилттай босгож, арав гаруй жил тасраад байсан Монголын арилжааны банкнуудын олон улсын зах зээл дэх санхүүжилтийн үйл ажиллагааг дахин сэргээлээ.
- J.P. Morgan Хөгжлийн Санхүүгийн Институттэй /JPM DFI/ хамтран анх удаа Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээг гаргалаа.
- Saison Investment Management, Agents for Impact, responsAbility зэрэг ОУ-ын байгууллагуудаас 38.0 сая ам.доллар тогтвортой санхүүжилт, бичил бизнесийг дэмжих зорилготой урт хугацаат санхүүжилтийг татан төвлөрүүлэв.
- АНУ-ын Bank of New York Mellon-д ам.долларын ностро дансыг нээж корреспондент банкнуудын сүлжээгээ өргөжүүллээ. Энэхүү данс нээгдсэнээр ам.долларын төлбөр тооцоог дамжуулагч банкны шимтгэлгүйгээр, улмаар илүү хурдан гүйцэтгэх боломжтой боллоо.
- Голомт банк гадаадын 18 банктай гадаад худалдааны санхүүжилтийн чиглэлээр хамтран ажиллаж байна. Нийт 123.0 тэрбум төгрөгийг техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, 203.0 тэрбум төгрөгийг шатахууны импортыг эдгээр гадаадын банкнуудтай хамтран аккредитив, гадаад баталгаа, худалдааны зээлийн үйлчилгээгээр дамжуулан санхүүжүүлэв.
- Голомт банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан шинэчлэл хөгжүүлэлтийг тогтмол хийж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгон, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлж ажилласнаар “Infosys Finacle” компаниас жил бүр зохион байгуулдаг “Infosys Finacle Innovation Awards-2024” арга хэмжээгээр Голомт банкны SocialPay болон SocialPay Junior аппликэйшнүүдийг олон улсын 100 гаруй байгууллагуудаас онцолж, “Maximizing Customer Engagement” төрөлд шилдгээр шалгарууллаа.
- Банк дижитал шилжилтийнхээ хамт харилцагчдадаа хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл ихтэй бүсүүдэд “ГӨҮ ТҮ МАРКЕТ”, “ЦЭНГЭЛДЭХ”, “АКОЯА” зэрэг салбар, орон нутагт “ХЭНТИЙ” салбараа нээж үйл ажиллагаагаа тэлэв.
- 2024 оны эхний хагас жилийн эцсээр банкны зээлийн багц өмнө оны мөн үетэй харьцуулахад 59%-р өсөж 6.4 их наяд төгрөгт хүрснээр зах зээлд эзлэх байр сууриа тэлэв. Мөн активын чанарын удирдлагыг хэрэгжүүлж чанаргүй зээлийн харьцааг 3.2%-д хүртэл бууруулаад байна.
- Банкны хагас жилийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 3.5 дахин өсөж 273.1 тэрбум төгрөгт хүрснээр жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 53%-д хүрэв. Нэгж хувьцаанд ногдох ашиг 337.8 төгрөг байна.
- Банк Монголбанкнаас тавьдаг шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.
- Банк эх орныхоо хөгжлийн Голомт байх эрхэм үүргээ хариуцлагатайгаар биелүүлж буй нийт ажилтнуудынхаа цалинг 2024/05/01-ээс эхлэх 30 хүртэл хувиар нэмэгдүүлэв.
- Голомт банк олон улсын зах зээл дэх цар хүрээгээ тэлж, Монгол Улсын банкны секторын долларын зах зээлийн оролцоог дахин сэргээж чадсан том амжилтыг онцолж, мөн улирал бүр санхүүгийн үзүүлэлтүүдээ тайлагнаж байгаа нь банкны ил тод байдал, санхүүгийн ухаалаг менежментийг улам тодотгож байна гээд инновац, дижитал шилжилт, харилцагчийн сэтгэл ханамж, тогтвортой банкны үйл ажиллагааны чиглэлд тууштай ажилласан Голомт банкныг Capital Finance International /CFI/ олон улсын медиа байгууллагаас 2024 оны Монгол Улсын Шилдэг Банкаар тодруулав.

3.2 Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

	2023Q3	2023Q4	2024Q1	2024Q2	Limits
Liquidity ratio	39.02%	38.34%	36.82%	34.50%	≥30%
LCR	133.8%	188.4%	136.9%	129.0%	≥100%
NSFR	120.2%	128.9%	115.7%	104.0%	≥100%

Харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын

зохистой харьцааг Монголбанкнаас 25% гэж тогтоосон байдаг. Голомт банкны хувьд дотооддоо Актив, пассивын бодлогын хүрээнд 2024 онд тус харьцааг 30%-аас дээш хангаж ажиллахаар тогтоосон бөгөөд эдгээр харьцаануудыг 2024 оны эхний хагас жилийн турш хангаж ажилласан байна.

Монголбанкны зохистой харьцаанаас гадна Голомт банк нь дотооддоо Базелын хорооноос боловсруулсан хөрвөх чадварын харьцаанууд болох LCR, NSFR-г тогтмол тооцоолж, хянаж явдаг. LCR буюу Liquidity Coverage Ratio нь банканд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхэд бэлэн мөнгөний хэрэгцээ доод тал нь хуанлийн 30 хоног байгаа эсэхийг илэрхийлэх харьцаа үзүүлэлт бөгөөд банк тус харьцааг 2023 онд тогтоосон лимитээс дээгүүр буюу 100%-аас дээш барьж ажилласан байгаа нь банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлээ зохистой түвшинд хангаж ажилласан болохыг илэрхийлж байна. Харин NSFR буюу Net stable funding ratio нь банкны урт хугацааны активын санхүүжилтийг хангах урт хугацааны тогтвортой пассивын хүрэлцээтэй байдлыг илэрхийлэх харьцаа үзүүлэлт ба тус харьцааг мөн 100%-аас дээш хангаж ажилласан нь банкны урт хугацааны хөрвөх чадварын эрсдэл нь зохистой түвшинд байгааг илтгэж байна.

Аливаа хөрвөх чадварын богино хугацааны эрсдэл үүссэн тохиолдолд банк нь эзэмшиж буй ТБҮЦ эсвэл ЗГҮЦ-аа барьцаалж Монголбанк болон бусад арилжааны банкнуудаас овернайт репо хэлцэл хийх, богино хугацаат своп хэлцэл хийх замаар төлбөрийн чадвараа хангах боломжтойгоос гадна тодорхой валютын хувьд хэрэгцээ үүссэн тохиолдолд бусад арилжааны банкнуудтай харилцан депозит байршуулах замаар эрсдэлээ удирдах боломжтой юм.

3.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл

2024 оны эхний хагас жилд Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2 удаагийн шийдвэрээр бодлогын хүүг 13%-с 11%-д хүргэж бууруулав. Оны эцэст 7.9% байсан инфляцын түвшин 6-р сарын эцсээр 5.1%-д хүртэл буурч төв банкны зорилтот интервалд хадгалагдлаа. Мөнгөний нийлүүлэлт 5-р сарын эцсээр өмнөх оноос 28%-иар өсөж 39.1 их наяд төгрөг хүрсэн байна. Ийнхүү өсөхөд төгрөгийн хадгаламж 4.9 их наяд төгрөг, төгрөгийн харилцах 1.8 их наяд төгрөг, гадаад валютын харилцах 2.6 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн бол долларын хадгаламж 800 тэрбумаар буурч 4.4 их наяд хүрчээ. Ам.долларын ханш өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй тогтвортой байв. 6-р сард болсон сонгуультай холбоотой 2024 оны 1-р хагас жилд төсвийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 47.1%-р өсөж, төрийн албан хаагчдын цалин 4-р сард 10-20% өссөн билээ. Ийнхүү богино хугацаанд хэрэглээ өсөж байгаатай холбоотой бодит эдийн засаг 1-р улиралд 7.8%-р өсөв. Орлого хэрэглээ өсч байгаатай холбоотойгоор банкны салбарын зээл 5-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 28%-иар өсөж 31 их наяд төгрөгт хүрч тэлэлт ажиглагдав.

Банк 2024 онд бизнесийн хувьд дараах чиглэлүүдийг баримтлан ажиллаж байна:

1. Дижиталчлалыг эрэлхийлэх чиглэлд
 2. Зээлийн шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, зээлийн удирдлагыг бэхжүүлэх
 3. Шинэ зээлийн болон бусад бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх
 4. ЖДҮ бизнес болон ритэйл бизнесээ бэхжүүлэх
 5. Тогтвортой санхүүжилтийг дэмжих
 6. Урт хугацааны хөрөнгө босгох
 7. Хөрөнгийн зах зээлд мэдээллийн ил тод харилцаа холбоог бий болгох
- Голомт банк монголын банкны салбарт технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан шинэчлэл хөгжүүлэлтийг тогтмол хийж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгон, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж ажиллав.
 - Банк дижитал шилжилтийнхээ хамт харилцагчдадаа хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл ихтэй бүсүүдэд “ГӨҮ ТҮ МАРКЕТ”, “ЦЭНГЭЛДЭХ”, “АКОЯА” зэрэг салбар, орон нутагт “ХЭНТИЙ” салбараа нээж үйл ажиллагаагаа тэллээ.
 - Голомт банк олон улсын зах зээл дээрээс гурван жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондыг амжилттай босгож, арав гаруй жил тасраад байсан Монголын арилжааны банкнуудын олон улсын зах зээл дэх санхүүжилтийн үйл ажиллагааг дахин сэргээлээ. Мөн Saison Investment Management, Agents for Impact, responsAbility зэрэг ОУ-ын байгууллагуудаас 38.0 сая ам.доллар тогтвортой санхүүжилт, бичил бизнесийг дэмжих зорилготой урт хугацаат санхүүжилтийг татан төвлөрүүлэв.

- 2024 оны эхний хагас жилийн эцсээр банкны зээлийн багц өмнө оны мөн үетэй харьцуулахад 59%-р өсөж 6.4 ихнаяд төгрөгт хүрснээр зах зээлд эзлэх байр сууриа тэлэв.
- Банк улирал бүр санхүүгийн тайлан, танилцуулгаа нээлттэй нийтэлж байгаа нь банкны ил тод байдлыг илэрхийлж байна.

3.4 Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлог

Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх мэдээлэл

Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

Эдгээр хэрэглүүрүүдийн үндсэн зорилго бол харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэрийг бэлэн байлгахад оршино. Баталгаа нь хэрэв харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг барагдуулах гэсэн цуцлагдах боломжгүй баталгаанууд бөгөөд эдгээр нь зээлтэй ижил төрлийн эрсдэл агуулдаг. Бичиг баримтын болон худалдааны аккредитив нь Банкнаас тодотгон заасан нөхцөлд гуравдагч этгээдэд тохиролцсон дүн хүртэлх хөрөнгийг авахыг харилцагчийн өмнөөс бичгээр зөвшөөрсөн үүрэг хүлээлт бөгөөд холбогдох бараа таваар буюу мөнгөн хадгаламжуудаар баталгаажсан байдаг тул зээлээс арай бага эрсдэлтэй байдаг.

Зээл, баталгаа болон аккредитив хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглаагүй хэсгээр Банк зээл олгох үүргийг хүлээдэг. Ашиглаагүй зээлийн шугамын хувьд харилцагч тухайн шугамыг ашигласан тохиолдолд л ашигласан зээлийн нийт хэмжээгээр Банк зээлийн эрсдэлд өртөх магадлалтай.

Гэвч харилцагч тодорхой зээлийн нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд зээлийн шугам авах эрх үүсдэг тул Банкны хүлээж болох алдагдлын дүн ашиглагдаагүй байгаа зээлийн шугамаас бага байдаг.

Мянган төгрөгөөр

2024 оны 06 сарын 30

Олгосон санхүүгийн баталгаа	71,790,813
Олгосон гүйцэтгэлийн баталгаа	396,398,778
Аккредитив	251,425,210
Ашиглаагүй зээлийн шугам	712,716,705

Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг **1,432,331,506**

Хасах нь: зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийн үнэ цэнийн бууралтын сангийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (2,707,491)

Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг **1,429,624,015**

4 Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/

2024.02.14- ны өдрийн хурлын шийдвэр

Хэлэлцсэн асуудал : Хамтран ажиллах гэрээ байгуулах тухай

Шийдвэр : Мандал Даатгал ХК-тай Хамтран ажиллах ерөнхий гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2024.02.16-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал : Бөөрөлжүүтийн тал ХХК-тай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулах зөвшөөрөл олгох тухай

Шийдвэр : Бөөрөлжүүтийн Тал ХХК-тай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулахыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2. Хэлэлцсэн асуудал : Steppe Beverage KFT- ийн нэр дээрх хувьцааг зээлийн барьцаанд хураан авах тухай

Шийдвэр :Зээлийн барьцаанд Steppe Beverage KFT-ийн нэр дээр байгаа АПУ ХК-ийн 52,193,070 ширхэг хувьцааг банк хураан авч, Голомт Капитал ҮЦК ХХК-д хэлцлийн шимтгэл төлөхийг дэмжив.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

3. Хэлэлцсэн асуудал : Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-тай холбоотой зээлийн хүсэлтийн тухай

Шийдвэр : Монголын Ипотекийн Корпорац ОССК ХХК-д хөрөнгө оруулалтын зээл олгохыг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2024.03.19-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал : Хамтран ажиллах гэрээ байгуулах тухай

Шийдвэр : Изи пэй ХХК-тай байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээний нөхцөл өөрчлөх болон сунгалтын гэрээг танилцуулсан нөхцөлийн дагуу баталгаажуулсугай.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2024.03.19-ны өдрийн хурлын шийдвэр

Хэлэлцсэн асуудал : Цэцэнс майнинг энд энерги ХХК-ийн зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Цэцэнс майнинг энд энерги ХХК-ийн зээлийн хүсэлтийг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2024.06.05-ны өдрийн хурлын шийдвэр

1. Хэлэлцсэн асуудал : Д.Баясгалантай холбоотой зээлийн хүсэлтийг шийдвэрлэх тухай

Шийдвэр : Д.Баясгалан-ийн зээлийн хүсэлтийг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2. Хэлэлцсэн асуудал : Бодь интернэшнл ХХК-тай холбоотой зээлийн шугам сунгах тухай

Шийдвэр : Бодь Интернэшнл ХХК-ийн зээлийн шугам сунгах хүсэлтийг зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	/Хавсралт №3/
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1	Голомт Файнэншил Групп ХХК	624,240,527	77.20%
2	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	42,120,816	5.21%
3	Бодь Интернэшнл ХХК	27,661,497	3.42%
4	Голомт Инвестмэнт Лимитэд	20,800,000	2.57%
5	Олон нийт	93,834,466	11.60%
	Нийт	808,657,306	100%

Голомт Файнэншил Групп ХХК	Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба Голомт банкны энгийн хувьцаа болон зарим хувьцаанд хөрвөх зээлүүдийг эзэмшдэг.
Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Вальют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад хувьцаа эзэмшдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмших болсон.
Бодь Интернэшнл ХХК	Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг.
Голомт Инвестмэнт Лимитэд	Голомт Инвестмэнт Лимитэд нь 2014 онд Монголын анхны томоохон групп компани болох “Бодь интернэшнл” ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.
Олон нийт	Голомт банк 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийснээр банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4-р сарын 15-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд 88.48 хувийн ирцтэйгээр танхим болон зайнаас хосолсон хэлбэрээр хурал зохион байгуулагдсан. Хурлын үр дүнд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан.

Шийдвэрүүд:

1. Голомт банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай;
3. “Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийг сонгох тухай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

Чүлтэм овогтой Мөнхцэцэг;
Жигжид овогтой Үнэнбат;
Шварценбах овогтой Урс Э.;
Дагва овогтой Мөнхтөр;
Очирпүрэв овогтой Ганжолоо;

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

Жэймс Б. Дваер;
Александр Пикер;
Роберт В. Ван Свитен;
Ханс Холзхакер;

Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах мэдээллүүдийг танилцуулсан.

1. Голомт банк ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Голомт банк ХК-ийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт;
3. 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол;
4. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай;

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Хагагтай
Ч.Мөнхцэцэг
ТУЗ-ийн дарга



Ноён
Д.Мөнхтөр
ТУЗ-ийн гишүүн



Ноён
Ж.Үнэнбат
ТУЗ-ийн гишүүн



Ноён
О.Ганжолоо
ТУЗ-ийн
гишүүн



Ноён
Б.Двайер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ноён
Александр Пикер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ноён
Роберт В.Ван
Свитен
ТУЗ-ийн Хараат
бус гишүүн



Ноён
Ханс Холзхакер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн


















З.Солонго
ТУЗ-ийн Нарийн
Бичгийн дарга



А.Туяа
Дотоод аудитын
газрын захирал

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:

	Гишүүд	Албан тушаал
Эрсдэлийн удирдлагын хороо	 Александр Пикер*	Хорооны дарга
	 Роберт В.Ван Свитен*	Хорооны гишүүн
	 Жэймс Б.Двайер*	Хорооны гишүүн

	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн
	 Ж. Үнэнбат	Хорооны гишүүн
Аудитын хороо	 Жэймс Б.Двайер*	Хорооны дарга
	 Александр Пикер*	Хорооны гишүүн
	 Ч.Мөнхцэцэг	Хорооны гишүүн
	 Д.Мөнхтөр	Хорооны гишүүн
	 Роберт В.Ван Свитен*	Хорооны гишүүн
Засаглал, ёс зүй, цалин урамшуулал	 Жэймс Б. Двайер*	Хорооны дарга
	 Александр Пикер*	Хорооны гишүүн
	 Ч.Мөнхцэцэг	Хорооны гишүүн
Нэр дэвшүүлэх хороо	 Александр Пикер*	Хорооны дарга
	 Роберт В.Ван Свитен*	Хорооны гишүүн



Ч.Мөнхцэцэг

Хорооны гишүүн

ГҮЙЦЭТГЭХ УДИРДАГА



Норихико Като
Гүйцэтгэх захирал



А.Одонбаатар
Гүйцэтгэх захирлын орлогч



Г.Ганболд
Ерөнхийлөгч



М.Сайнбилэг
Мэдээлэл технологи
хариуцсан захирал



С.Мөнхтуяа
Санхүүгийн удирдлагын
газрын захирал



М.Наранхүү
Зээлийн газрын захирал



Т.Отгон
Эрсдэлийн удирдлагын
газрын захирал



Б.Содболор
Нөөцийн удирдлагын
газрын захирал



Ц.Байгалмаа
Иргэдийн банкны газрын
захирал



Б.Сугар-Эрдэнэ
Байгууллагын банкны газрын
захирал



Г.Уянга
Хүний нөөцийн удирдлагын
газрын захирал



Н.Очирхуяг
Маркетинг, олон
нийтгэй харилцах газрын
захирал



А.Ганчимэг
Байгууллага хөгжлийн
газрын захирал



Ё.Пүрэвбат
Бүртгэл тооцооны газрын
захирал



Б.Энхзаяа
Олон улсын банкны газрын
захирал



Х.Пүрэвдорж
Захирааны газрын
захирал



О.Батцэнгэл
Мэдээлэл технологийн
газрын захирал



А.Нямсүрэн
Харилцагчийн үйлчилгээний
газрын захирал



Б.Учрал
Дижитал банкны газрын
захирал



Ж.Оюун
Дижитал шилжилтийн
газрын захирал



Б.Энхтүвшин
Зээл цуглуулах газрын
захирал



Г.Мандах
Харилцагчийн
бүртгэлийн газрын
захирал

7 Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ийн хурал, шийдвэр, тогтоолтой холбоотой мэдээлэл

2024 оны эхний хагас жилд Голомт банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нийт 15 удаа ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулж, нийт 23 асуудлыг хэлэлцэн зөвлөлдөж, 18 тогтоол, шийдвэрийг батлав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоол, шийдвэрүүд:

1. Стратеги хөрөнгө оруулалттай холбоотой
 - Нийт 6 тогтоол гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.
2. Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулахад чиглэсэн
 - Нийт 7 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.
3. Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулахад чиглэсэн
 - Нийт 3 бодлого журмыг сайжруулан шинэчилсэн байна.

Мэдээллийн ил тод байдал, тайлагнал

Голомт банк нь нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээ, мэдээллийг зохицуулагч байгууллагын холбогдох журмуудын дагуу цаг тухай бүрд олон нийтэд мэдээлэн ажилласан.

Тус тайлан мэдээ нь МХБ болон Голомт банкны “Хөрөнгө оруулагчдад” хэсэгт нээлттэй байрлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхэн нэг бүрчлэн танилцах боломжтой. Үүнд:

- Аудитлагдсан санхүүгийн тайлан
- Жилийн болон хагас үйл ажиллагааны тайлан
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан
- Ногдол ашиг хуваарилалтын тайлан
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлаас гарсан шийдвэр, тогтоол
- Компанийн засаглалын кодекс хэрэгжилтийн тайлан

- Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан
- Хагас жилийн санхүүгийн тайлан
- Тогтвортой хөгжлийн тайлан

Дээрх тайлан, мэдээнээс гадна Голомт банк нь 19,000 гаруй хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулж хурлаас гарсан тогтоол, шийдвэрийг тухай бүр олон нийтэд нээлттэй танилцуулсан.

Түүнчлэн Голомт Банк ХК нь Хөрөнгө оруулагчдын харилцааны алба шинээр үүсгэн байгуулж, хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээ мэдээлэл хүргэн, мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад үргэлж анхааран ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг:

Овог, нэр: Залаа-Уул Солонго

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг:

Овог, нэр: Энхцэцэг Тэлмэн

Албан тушаал: ТУЗ-ийн Ажлын алба - Хөрөнгө оруулалтын менежер

Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн огноо: 2024.07.19

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (IFRS-д нийцсэн)

ГОЛОМТ БАНК

2024/06/30

Төгрөгөөр

	Балансын зүйл	31/12/2023	30/06/2024
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,612,907,983,896.32	2,959,034,810,744.78
1.1.1	Бэлэн мөнгө	92,126,134,865.19	131,694,955,620.46
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	2,297,538,308,895.86	1,481,233,483,098.90
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,222,324,220,165.21	1,345,831,470,581.90
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	919,319,970.06	274,901,443.52
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,200,434,798,312.78	850,629,314,562.32
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	468,929,954,762.89	448,791,626,240.65
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	729,751,166,982.23	401,607,009,549.35
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	4,162,228,313.22	408,433,121.29
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(2,408,551,745.56)	(177,754,348.97)
1.3	Хөрөнгө оруулалт	1,180,837,682,538.54	1,071,816,178,259.52
1.3.1	Арилжааны үнэт цаас	107,297,209,270.67	155,311,293,036.79
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	579,471,649,723.16	422,865,945,906.04
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	194,751,332,307.36	181,377,808,574.37
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	254,472,103,290.00	264,425,948,050.00
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	31,219,463,993.14	31,936,304,301.79
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	13,625,923,954.22	15,898,878,390.53
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	4,712,108,704,574.54	6,419,160,614,100.96
1.4.1	Хэвийн зээл	4,300,325,085,164.68	6,198,710,413,979.96
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	273,989,445,415.14	197,108,483,102.67
1.4.3	Хэвийн бус зээл	29,393,312,614.82	29,167,470,653.86
1.4.4	Эргэлзээтэй зээл	34,277,627,122.19	11,894,136,985.52
1.4.5	Муу зээл	177,877,379,801.69	173,483,034,446.82
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(21,837,039,976.82)	(27,076,242,537.20)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	83,274,482,859.44	57,843,341,520.39
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(165,191,588,426.61)	(221,970,024,051.07)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	202,386,920,475.17	245,923,114,600.59
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	52,235,607,155.60	24,258,663,137.51
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	24,393,872,633.69	16,954,727,733.00
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	8,802,866,807.21	1,802,713,487.21
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	19,038,867,714.70	5,501,221,917.30
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	461,282,686,141.78	60,218,236,324.40

1.7.1	Бусад тооцоо	421,289,456,811.66	17,880,464,458.35
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	4,723,877,172.27	4,676,309,487.63
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	26,922,636,984.94	31,982,316,994.90
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	0.01	3,748,344,094.64
1.7.5	Татварын авлага	-	-
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	6,916,322,161.02	-
1.7.7	Бусад	1,430,393,011.88	1,930,801,288.88
1.8	Үндсэн хөрөнгө	151,082,991,465.88	593,129,470,991.57
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	6,586,475,093.94	6,586,475,093.92
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	29,101,737,564.69	14,488,112,928.15
1.11	Биет бус хөрөнгө	18,878,648,242.28	26,416,291,740.84
	Нийт хөрөнгийн дүн	11,627,844,235,461.50	12,271,661,282,484.60
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	3,978,501,265,062.87	3,401,778,308,555.05
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,978,499,653,120.44	3,401,326,795,904.67
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,611,942.43	451,512,650.37
2.2	Хадгаламж	3,745,457,557,781.49	3,801,317,784,090.33
2.2.1	Хугацаагүй хадгаламж	514,910,280,304.16	529,213,926,290.88
2.2.2	Хугацаатай хадгаламж	3,080,407,572,723.95	3,091,195,194,463.11
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	47,386,301,009.41	46,628,369,884.10
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	102,753,403,743.98	134,280,293,452.25
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,055,514,237,163.97	2,343,467,092,309.09
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	285,919,785,770.26	1,087,453,215,737.68
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,761,250,205,039.67	1,256,422,883,712.08
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(8,799,485,136.30)	(8,981,319,712.40)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	17,143,731,490.35	8,572,312,571.73
2.4	Бусад эх үүсвэр	517,009,311,375.35	1,219,904,817,791.68
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	990,189,196,795.73
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	28,890,166,503.61	29,221,921,436.99
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	303,440,299,618.09	20,794,800,910.42
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	17,164,263,860.05	38,366,042,139.62
2.4.6	Бусад	162,080,041,422.60	130,064,084,150.94
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	(5,445,552,659.06)
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	5,434,539,971.00	16,714,325,017.05
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	2,890,937,760.03	40,171.25
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	187,688,316,244.60	279,440,556,419.90
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	69,691,887,333.69	89,368,384,777.76
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	10,556,753,512,722.00	11,135,276,984,115.10

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
3			
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	202,164,326,500.00	202,164,326,500.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	202,164,326,500.00	202,164,326,500.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	301,481,119,995.04	301,481,119,995.04
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	6,666,262,716.14	6,666,262,716.14
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	460,718,070,952.43	620,184,896,521.47
3.6	Бусад өөрийн хөрөнгө	100,060,942,575.92	5,887,692,636.84
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	345,396,423.02	340,396,423.02
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	94,754,925,266.62	-
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-
3.6.8	Бусад	4,960,620,886.28	5,547,296,213.82
	Өөрийн хөрөнгийн дүн	1,071,090,722,739.53	1,136,384,298,369.49
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	11,627,844,235,461.50	12,271,661,282,484.60

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүүгийн удирдлагын газрын захирал

СУГ Бүртгэлийн бодлого, хяналтын хэлтсийн захирал



Норихико Като

С.Мөнхтуяа

С.Урантөгс

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ГОЛОМТ БАНК

2024/06/30

Төгрөгөөр

Он, сар, өдөр

	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Хүүгийн орлого	966,457,398,459.23	580,080,339,988.04
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	22,961,734,912.63	11,268,765,360.28
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	25,015,845,852.14	6,404,730,483.21
1.3	Үнэт цаасны	175,446,481,381.98	92,043,329,724.75
1.4	Зээлийн	590,666,875,010.64	406,722,879,660.99
1.5	Бусад хүүгийн орлого	152,366,461,301.84	63,640,634,758.81
2	Хүүгийн зардал	507,708,579,546.46	322,524,680,413.26
2.1	Харилцахад төлсөн хүү	29,662,945,373.46	32,146,378,133.46
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	252,475,567,593.89	165,659,087,551.41
2.3	Зээлийн хүүгийн зардал	74,825,704,691.19	39,796,346,767.91
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	-	14,050,899,050.91
2.5	Бусад хүүгийн зардал	150,744,361,887.92	70,871,968,909.57
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	458,748,818,912.77	257,555,659,574.78
4	Эрсдэлийн сангийн зардал	(27,169,521,067.81)	-
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	-	-
4.2	Үнэт цаасны	-	-
4.3	Зээлийн	(27,169,521,067.81)	-
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	485,918,339,980.58	257,555,659,574.78
6	Бусад орлого	296,005,008,280.00	309,274,159,726.86
6.1	Хүүгийн бус орлого	287,692,785,095.14	296,715,503,507.23
6.1.1	Арилжааны орлого	182,506,774,952.93	134,374,117,803.33
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,924,782,358.82	62,753,919,586.93
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	103,261,227,783.39	57,705,181,382.72
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	-	41,882,284,734.25
6.2	Бусад орлого, олз	8,312,223,184.86	12,558,656,219.63
7	Бусад зардал	515,888,252,722.73	209,201,129,775.40
7.1	Хүүгийн бус зардал	510,380,923,731.47	205,676,826,242.77
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	11,268,700,744.73	7,777,559,430.44
7.1.2	Арилжааны зардал	1,239,453,477.63	-
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	240,125,321,476.85	38,690,635,657.45
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	58,303,977,381.01	33,889,135,537.34
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	199,443,470,651.25	125,319,495,617.54
7.2	Бусад зардал, гарз	5,507,328,991.26	3,524,303,532.63
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	266,035,095,537.85	357,628,689,526.24
9	Орлогын татварын зардал	56,864,050,560.71	84,491,105,218.02
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	209,171,044,977.14	273,137,584,308.22
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	209,171,044,977.14	273,137,584,308.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого	40,767,083,046.76	586,675,327.54
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-	0.00
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	40,767,083,046.76	586,675,327.54
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	-	-
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	-	-
13.5	Бусад	-	-
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	249,938,128,023.90	273,724,259,635.76

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүүгийн удирдлагын газрын захирал

СУГ Бүртгэлийн бодлого, хяналтын хэлтсийн захирал



Норихико Като



С.Мөнхтуяа



С.Урантөгс

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ГОЛОМТ БАНК

30/06/2024

Банкны нэр

Он, сар, өдөр

	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	266,035,095,537.85	357,628,689,526.24
1.2	Орлого, зардлын тохируулга:	(449,290,864,724.41)	301,346,397,562.75
1.2.1	Эрдэлийн сангийн зардал (+)	(24,178,292,024.20)	23,678,379,753.52
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	35,389,742,574.11	28,499,278,099.11
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	4,300,803,186.92	262,263,823,047.51
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(840,732,554,686.59)	(112,533,455,170.40)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	363,440,438,549.29	99,198,224,538.65
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	12,488,997,676.06	240,147,294.35
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	-	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	1,745,128,898,146.92	(2,604,927,115,069.54)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	151,987,247,372.44	351,989,746,117.65
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	53,309,716,985.46	(48,014,083,766.11)
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(1,222,173,620,928.51)	(2,005,150,717,998.74)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	230,906,299,591.31	7,939,209,488.41
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	1,681,232,206.26	11,118,006,513.26
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	2,250,056,999,974.03	(853,637,595,067.02)
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	78,475,246,856.73	(79,806,391,272.22)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	129,223,512,593.70	(27,880,264,406.12)
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	71,662,263,495.49	38,514,975,321.35
1.4	Бусад тохируулга:	421,912,938,964.95	100,917,765,881.10
1.4.1	Авсан хүү (+)	832,609,887,942.73	449,019,659,314.12
1.4.2	Төлсөн хүү (-)	(323,631,444,028.75)	(285,453,755,403.08)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(87,065,504,949.03)	(62,648,138,029.94)
1.4.4	Эрдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	-	-
1.4.5		-	-
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,983,786,067,925.31	(1,845,034,262,099.46)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	403,281,102,706.48	404,448,784,230.05
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	8,811,796,614.98	31,250,955,176.61
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	3,690,000,000.00	-
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	390,779,306,091.49	315,892,007,514.14
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	-	57,305,821,539.30
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.10	Бусад мөнгөн орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(1,054,028,652,892.02)	(252,807,588,264.23)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,553,696,331.94	38,071,983,260.40
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,299,094,877.09	-
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	843,094,384,050.00	159,286,303,697.02
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	36,317,000.00	55,449,301,306.81
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	176,045,160,632.99	-
2.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(650,747,550,185.55)	151,641,195,965.83

		***	***
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,557,560,501,330.79	1,080,670,745,453.98
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	4,557,560,501,330.79	1,080,670,745,453.98
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.5	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(4,473,590,558,560.17)	(83,781,588,962.10)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	4,422,909,852,632.46	11,002,431,422.10
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	10,247,840,527.71	-
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-
3.2.5	Төлсөн ногдол ашиг	40,432,865,400.00	72,779,157,540.00
3.2.6	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	83,969,942,770.62	996,889,156,491.88
4	Валотын ханшийн зөрүү	(40,552,969,174.42)	42,630,736,490.22
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,376,455,491,335.97	(653,873,173,151.54)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,236,452,492,560.35	3,612,907,983,896.32
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,612,907,983,896.32	2,959,034,810,744.78

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүүгийн удирдлагын газрын захирал

СУГ Бүртгэлийн бодлого, хяналтын хэлтсийн захирал



Норихико Като

С.Мөнхтуяа

С.Урантөгс

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ГОЛОМТ БАНК

2024/06/30

Он, сар, өдөр

Төгрөгөөр

	өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	6,994,662,029.30	25,122,998,459.01	307,974,022,770.04	843,737,129,753.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					42,721,834,630.54	(24,553,201,845.13)	18,168,632,785.41
3	Залруулсан үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	6,994,662,029.30	67,844,833,089.55	283,420,820,924.91	861,905,762,538.80
4	Тайланг үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	180,806,784,419.63	180,806,784,419.63
5	Бусад дэлгэрэнгүй орлого					35,806,462,398.79		35,806,462,398.79
6	Өмчид гарсан өөрчлөлт					(103,305,899,065.32)	12,109,119,021.53	(91,196,780,043.79)
7	Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	(40,432,865,300.00)	(40,432,865,300.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(328,399,313.16)	0.00	328,399,313.16	0.00
9	2023 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	6,666,262,716.14	345,396,423.02	436,232,258,379.23	946,889,364,013.43
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					99,715,546,152.92	24,485,811,621.17	124,201,357,774.09
11	Залруулсан үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	6,666,262,716.14	100,060,942,575.94	460,718,070,000.40	1,071,090,721,787.53
12	Тайланг үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	273,137,584,308.22	273,137,584,308.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого							-
14	Өмчид гарсан өөрчлөлт					(94,173,249,939.10)	(40,891,600,247.15)	(135,064,850,186.26)
15	Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	(72,779,157,540.00)	(72,779,157,540.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-		-
17	2024 оны 06-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	6,666,262,716.14	5,887,692,636.84	620,184,896,521.47	1,136,384,298,369.49

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүүгийн удирдлагын газрын захирал

СУГ Бүртгэлийн бодлого, хяналтын хэлтсийн захирал



Норихико Каго

С.Мөнхтуяа

С.Урантөгс



АУДИТЫН ХОРООНЫ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ, ШИЙДВЭР

2024 оны 06 сарын 14

Дугаар 24/05

Улаанбаатар хот

Хурал Zoom platform-оор, 2024 оны 06 сарын 14-ний өдөр болсон бөгөөд дараах гишүүд оролцов:

Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Жэймс Б.Двайер

Гүйцэтгэх захирал Н.Като

Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг

Гүйцэтгэх захирлын орлогч А.Одонбаатар

Аудитын хорооны гишүүн Д.Мөнхтөр

ТУЗ-ийн НБД З.Солонго

Аудитын хорооны хараат бус гишүүн Р.В.ван Свитен

ДАГ-ын захирал А.Туяа

АХ-ны гишүүн А.Пикер ажил давхардсан тул хурлаас чөлөө авсан.

Хуралдсан цаг: 2024.06.14-ний өдөр, 10:00 – 13:00

Танилцуулах асуудлууд:

- Санхүүгийн үр дүн (2024 оны 5-р сарын 31-ний байдлаар) болон эхний хагас жилийн төсөөлөл
- 2023 оны хөндлөнгийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмж
- Холбоотой этгээдийн тайлан
- Өрсөлдөгчийн судалгаа
- Бондын хаалтын тайлан

Танилцуулга 1. Санхүүгийн үр дүн (2024 оны 5-р сарын 31-ний байдлаар) болон эхний хагас жилийн төсөөллийг Гүйцэтгэх захирал Н.Като, СУГ-ын захирал С.Мөнхтуяа нар танилцуулав.

Тэмдэглэл:

- ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг Голомт банк 2024 оноос эхлэн өмнөх онуудтай харьцуулахад илүү эрчтэй ажиллаж байгаа тул зээлтэй холбоотой эрсдэл нэмэгдэнэ, нэмэгдэж буй эрсдэлийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авч байгаа талаар болон хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэх ямар төлөвлөгөө байгааг асуусан бөгөөд Гүйцэтгэх захирлын орлогч А.Одонбаатар шинээр байгуулсан Зээл цуглуулах газрын үйл ажиллагаа сайн явж байгаа, зээлийн тэлэлтийг эрчтэй хийж байгаа ч гэсэн зээлийн шалгуурыг бууруулаагүй, мөн зээлийн мониторингийн хэлтсийн үйл ажиллагаа сайн байгааг дурдсанаас гадна Кредит карттай холбоотой хураамж, шимтгэлийг өсгөх зорилгоор зохион байгуулж байгаа 6 аяны үр дүн сайн байгаа, мөн КУБ-ын шимтгэлийг өсгөх зорилгоор КУБ-ын шимтгэлийг тохирох эрхийг салбарын захирлуудад өгсөн талаар хариулав.

Шийдвэр:

- Зээлтэй холбоотой эрсдэлийг бууруулахаар хийгдэж буй ажлууд болон хүүгийн бус орлогыг өсгөх төлөвлөгөөг ТУЗ-ийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Н.Като болон Гүйцэтгэх захирлын орлогч А.Одонбаатар нарт даалгав.

Танилцуулга 2. 2023 оны хөндлөнгийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг Гүйцэтгэх захирал Н.Като, СУГ-ын захирал С.Мөнхтуяа нар танилцуулав.

Тэмдэглэл:

- Аудитын хорооны дарга Жэймс Б.Двайер аудитын тайлан reissue хийсэнтэй холбоотой ямар зардлууд гарсан талаар асуусан бөгөөд СУГ-ын захирал С.Мөнхтуяа KPMG-д 52,500 ам.доллар, PwC-д 3650 ам.доллар төлсөн талаар хариулав.

Танилцуулга 3. Холбоотой этгээдийн тайланг Гүйцэтгэх захирал Н.Като, СУГ-ын захирал С.Мөнхтуяа нар танилцуулав.

Танилцуулга 4. Өрсөлдөгчийн судалгааг Гүйцэтгэх захирал Н.Като, СУГ-ын захирал С.Мөнхтуяа нар танилцуулав.

Танилцуулга 5. Бондын хаалтын тайланг Гүйцэтгэх захирал Н.Като, НУГ-ын захирал Б.Содболор нар танилцуулав.

Тэмдэглэл:

- Аудитын хорооны гишүүд Бондын ажлын хэсэгт амжилттай ажилласан ажлын хэсэгт баяр хүргэв. Аудитын хорооны гишүүн Р.В.ван Свитен Бондын нөхцөл дээр тусгасан ногдол ашигтай холбоотой хязгаарлалт Голомт банкны Хувьцааны танилцуулга дээр дурдсан харилцагчдад амалсан ногдол ашгийн хувьтай зөрчилдөх эсэхийг асуусан бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Солонго хязгаарлалт нь ногдол ашиг төлөлтийн харьцаа 50%-иас ихгүй байх гэсэн бөгөөд Хувьцааны танилцуулга дээр эхний жил 20%, 2 дахь жил 40%, 3 дахь жил 50% байна гэж тусгасан тул хязгаарлалт, амлалт 2 зөрчилдөхгүй талаар хариулав.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.МӨНХЦЭЦЭГ

“ГОЛОМТ БАНК ХК” ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

/2023 оны 12 сарын 31-ны байдлаар/

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлэх 103,317,524,755 төгрөгөөс үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн:

- Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлуудыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулна;
- Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт сайжирч эрсдэлээр жигнэсэн актив буюу зээлийн багцын хэмжээг ойролцоогоор 790 гаруй тэрбум төгрөгөөр өсгөх боломж бүрдэж, ирээдүйн бизнесийн тогтмол өсөлтийг бий болгох гол суурь болно.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Банк 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд анхдагч зах зээлийн арилжаагаар хувьцааныхаа 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,285 төгрөгөөр нийтэд санал болгов. Захиалгын эрэлт өндөр байсан тул олон нийтэд санал болгосон хувьцааны 15 хувьтай тэнцэх хэмжээний буюу 12,060,411 ширхэг хувьцааг нэмэлтээр гаргаж, нийт 118,815,152,890 төгрөгийг /нийт хувьцааны 11.43 хувь/ олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн 118,815,152,890 төгрөгийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардал: 2.1 тэрбум төгрөг

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 12 сарын 06-ны өдрийн 1/4659 тоот зөвшөөрлөөр 2022 оны 12 сарын 08-ны өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төвөөр дамжин нийт 118,815,152,890 төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс СТОУС дагуу үнэт цаас гаргахтай шууд хамаарал бүхий зардлыг ААНОАТ-ын дүнгээр цэвэршүүлэн 2,103,028,206 төгрөгийг хасагдуулж цэвэр 116,712,124,684 төгрөгөөр банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн.

2. Зээл олголт 116.7 тэрбум төгрөг

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт /Монголбанкны тайлангаар/

Үзүүлэлт (сая төгрөг)	11/30/2022	12/31/2022	31/12/2023	Difference (12/31/2023-11/30/2022)	
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	673,839	811,978	940,109	266,270	40%
Өөрийн хөрөнгө (Ө.Х)	673,839	811,978	940,109	266,270	40%
Эрсдэлээр жигнэсэн актив	4,600,320	4,601,535	5,926,932	1,326,612	29%
I зэрэглэлийн Ө.Х-ийн хүрэлцээ (>9.0%+нөөц 4.0%)	14.65%	17.65%	15.86%	1.21%	
Нийт Ө.Х-ийн хүрэлцээ (>12.0%)	14.65%	17.65%	15.86%	1.21%	

2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөртэй харьцуулахад банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцох нийт өөрийн хөрөнгө 266.3 тэрбум төгрөгөөр буюу 40 хувиар өсөж 940.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх хугацаанд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 1.21 нэгж хувиар нэмэгдэж банкны эрсдэл даах чадвар сайжирсанаар зээлийн багцын хэмжээг өсгөх боломж бүрдсэн хэвээр байна.

Банк 2022/12/09-өөс 2023/11/10-ны хооронд харилцагчдад нийт 7,854.6 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу эрсдэлтэй активын хамгийн багадаа 13 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай байдаг. Нийт өөрийн хөрөнгийн 11.43 хувийг олон нийтэд нээлттэй хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө эзэлж байх тул дээрх хугацаанд шинээр олгосон зээлийн 116.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн 116.7 тэрбум төгрөгийн зээлийг төлөвлөгөөний дагуу Том аж ахуйн нэгжийн бизнесийн зээлд 43.5 тэрбум /37.3 хувь/, ЖДБ болон иргэдэд олгосон бизнесийн зээлд 30.3 тэрбум /26.0 хувь/, Хэрэглээний зээлд 24.2 тэрбум /20.7 хувь/, Орон сууцны зээлд 18.7 тэрбум /16.0 хувь/ бүтцээр олгоод байна.

Банк 2023/11/10-ны байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгөө бүрэн зарцуулж дуусгалаа.